



ДААТГАЛ
SINCE 1994

Сэнтрал тауэр, 13-р давхар, 1305 - 1307 тоот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2,
УБ-14200, Монгол улс
Утас: 7720 0088, И-мэйл: info@arddaatgal.mn,

2023 он 12 сар 13 өдөр

Дугаар 20/23

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашгийн журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн “Ногдол ашгийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх Захирал (Г.Цогбадрах)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

ДАРГА



О.ОДБАЯР

12 сарын 11 өдрийн 12-д тоот тогтоолын хавсралт



АРД ДААТГАЛ ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү ногдол ашгийн журам (цаашид “журам” гэх)-аар Ард даатгал ХК (цаашид “компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэр гаргах, энэ талаарх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журмыг компанийн ТУЗ-өөс боловсруулан батлаж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглана.
- 1.3 Журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Компанийн дүрэм, зохих байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмуудад нийцсэн бөгөөд Компани ногдол ашиг хуваарилах, төлөх ажиллагаанд дээрх хууль, дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Ногдол ашгийн бодлого

- 2.1 Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг Компанийн бизнесийн үйл ажиллагаанд зүй зохистой, үр ашигтай захиран зарцуулж, хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийг зохистой хэмжээнд байлгах бодлогыг баримтална.
- 2.2 Компанийн ногдол ашиг хуваарилах асуудлыг ТУЗ хэлэлцэн батална.
- 2.3 Компани дараах нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
 - 2.3.1 Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
 - 2.3.2 Ногдол ашиг төлсний дараа компани өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 2.3.3 Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүгдийг нь эргүүлэн авсан байх;
- 2.4 Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргаж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.
- 2.5 Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн нөхцөлд тухайн шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчдэд тайлагнана.
- 2.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр, ногдол ашиг төлөх өдөр зэргийг тусгана.
- 2.7 Ногдол ашгийг бүрэн төлж дуусах хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсанаас хойш хуанлийн 60 хоногоос хэтрэхгүй байна.
- 2.8 Ногдол ашиг төлсний дараа компани өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа төлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийг бичгээр мэдэгдэх үүргийг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

Гурав. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлох

- 3.1 ТУЗ нь ногдол ашгийг тодорхойлсон тооцооллыг тухайн жилд хэлэлцэж гаргана.
- 3.2 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг болдог учраас энэ шийдвэр нь компанийн бодит байдлыг зөв тусгасан үзүүлэлт байна.
- 3.3 Компанийн санхүүгийн байдлаас шалтгаалан жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Хуваарилах дүн нь компанийн тухайн жилийн цэвэр ашгийн 30-50 хувь байна.
- 3.4 Бэлэн мөнгөнөөс бусад хэлбэрээр ногдол ашиг тараах тохиолдолд тухайн эд хөрөнгө, үнэт цаасны үнэлгээг ТУЗ-аас тогтооно.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, төлөх

- 4.1 ТУЗ нь ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тухайн өдрөөр тасалбар болгосон нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрх үүснэ.
- 4.2 Компани ногдол ашиг хуваарилахад Компанийн тухай хуулийн 46-67 дугаар зүйлд заасан нөхцөл, журмыг хангасан байна.
- 4.3 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрт дараах зүйлсийг тусгана. Үүнд:
- 4.3.1 Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
 - 4.3.2 Ногдол ашгийг төлөх хугацаа;
 - 4.3.3 Төлөх арга, хэлбэр (эрх бүхий зуучлагчаар дамжуулах, эд хөрөнгө, бэлэн мөнгө, бусад үнэт цаасаар төлөх гэх мэт);
 - 4.3.4 Бүртгэлийн өдөр;
 - 4.3.5 Бусад холбогдох асуудал;
- 4.4 Ногдол ашиг хуваарилах талаар мэдээллийг компани өөрийн цахим хуудсаар болон өдөр тутам хэвлэгдэж, орон даяар тараагддаг сонингоор мэдээлнэ. Мэдээлэлд нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ, төлөх хугацаа, арга зам, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгана.
- 4.5 Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд уг хувьцаанд ногдох ногдол ашгийг авах эрх нь хуучин хувьцаа эзэмшигчид үлдэнэ.
- 4.6 Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр өглөгийн бүртгэл тусгайлан бүртгэнэ.

Тав. Тайлагнах

- 5.1 Ногдол ашгийн хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

Зургаа. Хариуцлага

- 6.1 Компани өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол зохих ёсоор ногдол ашиг аваагүй хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох ба хувьцаа эзэмшигчид алданги төлсөн бол үүнээс үүдэн компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх удирдлага хариуцна.